

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.340.10

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Цахилгаан тоног төхөөрөмжтэй ажиллах үеийн хамгаалалтын багаж, хэрэгсэл ажлын тусгай хувцас	MNS 4660 : 202X
Occupational Safety and Health Protective equipment and tools when working with electrical equipment Workwear	MNS 4660:1998-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын ... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь ... оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Ажилтан цахилгаан гүйдлийн нөлөөллөөс хамгаалагдаж, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглах ёстой хамгаалах хэрэгсэл, тэдгээрийн чанар, бүтэц, хэрэглээний нөхцөл, шаардлагыг тогтооно.

2 Нэр томьёо, тодорхойлолт

2.1

Цахилгаан орон шаталт

Өндөр хүчдэлтэй цахилгаан орон болон цахилгаан гүйдэлтэй холбоотойгоор хүний биед үүсэх түлэгдэл, гэмтлийн хэлбэр

2.2

Цахилгаан нум

Цахилгаан гүйдэл нь хий дундуур дамжих үзэгдэл

2.3

Ажлын тусгай хувцас

Ажлын байрны аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий зэрэг хэрэгслийг

2.4

Хувийн хамгаалах хэрэгсэл

Хөдөлмөрлөх явцад ажлын байрны аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хүнийг хамгаалах зориулалт бүхий хэрэгслийг

3 Ерөнхий зүйл

3.1 Цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцан ажиллаж байгаа ажилтнуудыг цахилгаан гүйдэлд нэрвэгдэх, цахилгаан нум, цахилгаан орон шаталтын бүтээгдэхүүний үйлчилгээ, өндрөөс унах зэргээс хамгаалж, хөдөлмөрлөх нөхцөлийг

сайжруулж, ингэснээр аливаа ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг биелүүлэхэд энэхүү стандартын зорилго оршино.

3.2 Хамгаалалтын багаж хэрэгсэлд хувийн хамгаалах хэрэгсэл, ажлын багаж хамаарагдана.

3.3 Стандартын заалтуудыг Эрчим хүчний яамны бүтцэд байдаг цахилгаан шугам сүлжээний газрууд болон түүний бүх нэгж дагаж мөрдөнө.

3.4 Хувийн хамгаалах хэрэгслийн нормативыг А хавсралтаар үзүүлэв.

3.5 Хувийн хамгаалах хэрэгсэл ба ажлын багажийн дэлгэрэнгүй бүртгэлийг В хавсралтаар үзүүлэв.

3.6 Хувийн хамгаалах хэрэгсэл ба ажлын тусгай хувцасны захиалгын маягтыг С хавсралтаар үзүүлэв.

4. Хамгаалалтын багаж хэрэгсэл, ажлын тусгай хувцсаар хангах зохион байгуулалтын арга хэмжээ

4.1 Хамгаалалтын багаж хэрэгсэл, ажлын тусгай хувцсаар хангах зохион байгуулалтын арга хэмжээ нь дараах 5 хэсгээс бүрдэнэ.

а. Тодорхой нарийн судалгаатай байх

б. Захиалга гаргаж өгсөн байх

с. Захиалгын дагуу олж бэлтгэх

д. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хамгаалалтын багаж хэрэгсэл, ажлын тусгай хувцсыг актаар устгах

е. Шинээр тавьж олгох

4.2 Харьяа газар түүний салбар, хэлтэс, нэгжүүд нь өөрийн бригад тэргэнцрүүд дээр ашиглаж байгаа хамгаалалтын хэрэгсэл, ажлын багажийн талаар А хавсралт заасан маягтын дагуу дэлгэрэнгүй судалгаатай ажиллана.

4.3 Шинээр авах буюу туршуулж баталгаатай болгох хувийн хамгаалах хэрэгсэл болон ажлын тусгай хувцасны захиалгыг жил бүрийн 7-р сарын 1-ний дотор гаргаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байцаагч, инженерээр хянуулж хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал, туршилтын хэсгийн ажлын төлөвлөгөөнд тусгуулсан байх.

Харин богино хугацаанд туршигддаг хувийн хамгаалах хэрэгслийг нэг сарын өмнө туршилтын хэсэгт өгнө.

4.4 Ашиглагдаж байгаа хувийн хамгаалах хэрэгслийг туршилтын баталгаат хугацаа дуусахаас 7-10 хоногийн өмнө туршилтын хэсэгт хүлээлгэн өгнө.

4.5 Туршилтын хэсэг нь хүлээн авсан хувийн хамгаалах хэрэгслийг 7 хоногт багтаан туршиж биеэр буюу утсаар уг хувийн хамгаалах хэрэгслийг хүлээлгэн өгсөн алба салбарт туршигдаж бэлэн болсон тухай мэдэгдэнэ.

4.6 Шинээр авах хамгаалалтын багаж хэрэгсэл, ажлын тусгай хувцасны захиалгыг алба, салбар, хэлтсээс С хавсралтын дагуу хийнэ.

4.7 Бүх захиалгыг нэгтгэж удирдах дээд байгууллагатай тохиролцож улмаар захиалгын дагуу олж бэлтгэх асуудлыг материал хангамжийн алба гүйцэтгэнэ.

4.8 Ашиглалтын шаардлага хангахгүй болсон хамгаалалтын багаж хэрэгсэл, эдэлгээний нормт хугацаа дууссан буюу эдэлгээний нормт хугацаа дуусаагүй боловч цаашид ашиглаж ажил үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон ажлын тусгай хувцас

зэргийг шалган үзэж, устгаж болох тухай /ашиглаж болохгүй болсон тухай / акт гаргасны дараа устгана.

4.9 Акт тогтоохдоо ажилтны хариуцлага, сахилга бат ашиглалтын буруу буюу ашиглалтын явцад зайлшгүй байх шалтгаанаар ашиглах боломжгүй болсон тухай тодорхой зааж тэмдэглэсэн байна.

4.10 Ажлын өвөл, зуны нормын ажлын тусгай хувцасны батлагдсан хугацаа дууссан эсэхийг ажилтны картаар тулган, няравтай хамтран шалгана.

4.11 Захиалгын дагуу олж бэлдсэн ажлын багаж хэрэгсэл, ажлын тусгай хувцсыг тавьж олгохдоо хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженерийн хяналт зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэнэ.

4.12 Ажлын зуны тусгай хувцсыг жил бүрийн 4-р сард, өвлийн хувцсыг 9-р сард тус тус олгосон байхаар бэлтгэнэ.

4.13 Хамгаалалтын бүх багаж хэрэгсэл, ажлын тусгай хувцас нь өөрийн гэсэн тэмдэг дугаартай байна. Энэ тэмдэг дугаарыг багаж хэрэгслийн бариул, бие дээр нүдэнд харагдахуйц хэсэгт дарж бичсэн байна.

4.14 Алба салбарын удирдлага нь багаж, ажлын тусгай хувцасны карт дээр уг дугаарыг заавал тэмдэглэсэн байна. Энэ дугаар нь бусад байгууллага ажилтны багаж, хувцастай солигдохгүй байхаар тэмдэглэнэ.

5. Хөдөлмөрийн багаж хэрэгсэл, ажлын тусгай хувцсыг ашиглаж, хадгалж, хамгаалах талаар

5.1 Хувийн хамгаалах хэрэгслийг ашиглах, хадгалах асуудал "Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг баримтлан шийдвэрлэгдэнэ.

5.2 Ажлын багажийг ашиглахын өмнө бүрэн бүтэн, бат бэх байдалд заавал үзлэг хийсэн байна. Үзлэг, шалгалтыг ажлын байранд багаж эзэмшигч ба ажлыг удирдагч, ажил гүйцэтгэгч нар хийнэ.

5.3 Хамгаалалтын багаж хэрэгслийн хангамж хүрэлцээг сайжруулахын тулд аж ахуйн нярав дээр төвлөрүүлэн хадгална.

5.4 Аж ахуйн болон багажийн нярав нь багаж хэрэгсэл хадгалахад зориулагдсан тавиур бүхий зориулалтын өрөө байртай байна.

5.5 Ажлын тусгай хувцсыг зөвхөн ажил үүргээ гүйцэтгэж байх хугацаанд өмсөж хэрэглэнэ. Тэргэнцрүүд бүр ажилтан хувцасны шүүгээгээр хангагдсан байх ёстой.

5.6 Ажлын тусгай хувцас өмсгөж ажилд гаргах асуудлыг хэсэг, нэгжийн дарга, мастер нар хариуцан өглөө бүр шалгаж байна.

5.7 Хамгаалалтын багаж хэрэгсэл, ажлын тусгай хувцсыг зөв ашиглаж, гамтай эдлэх хариуцлагыг эзэмшигч ажилтан хариуцна.

5.8 Эзэмшигчийн буруугаар үрэгдүүлсэн буюу дахин ашиглах боломжгүй болсон, эвдэрсэн багаж хэрэгсэл, урагдсан ажлын тусгай хувцсыг дотоод журамд зааснаар суутган төлүүлнэ.

ТӨГСӨВ.

А хавсралт
(норматив)

Хүснэгт А.1

Хувийн хамгаалах хэрэгслийн норматив

№	Хувийн хамгаалах хэрэгслийн нэр /хүчдлийн төрөл/	Хэмжих нэгж	220/110/35 10 Кв-ын дэд станц	110/35/10 Кв-ын дэд станц	35/6 Кв-ын дэд станц	Шуурхай үйлчилгээ диспетчерийн хэсэг	Салбар
1	Дүн: Хүчдэл заагч	ш	2	1	1	Бригад бүрд	10
1а	1000В хүртэл /ТПП МИН – 1/	ш	-	1		2	
1б	2-10 Кв /УВН-80 М/	ш	1	1	1	2	
1в	35-110 Кв /УВН-35-220/	ш	1			1	
1г	Дүн: Фазировка шалгагч УВНУ-2-10 кв	ш				1	
1д	ТФ-2-10кв	ш				1	
2	Оператив штанги	ш					
2а	2-10кв/ШОУ-15/	ш		1	1	2	
2б	35 Кв /ШОУ-35/	ш	1	1	1	1	
2в	110Кв/ШОУ –110/	ш	1	1		1	
2г	220 Кв /ШОУ-220/	ш	1			1	
3	Зөөврийн штангатай газардуулагч	ш					
3а	1000в хүртэл /ШЗН-1/	ш				2	6
3б	6-10 Кв а/ш / ШЗН-10/ д/с / ШЗП-15/	ш		2	2	4	
3в	35 Кв а/ш /ШЗЛ-35/ д/с / ШЗЛ –35	ш		2	2	2	
3г	110 Кв а/ш /ШЗП-110/ д/с / ШЗП-110/	ш	2	2			
3д	220 Кв а/ш /ШЗП-220/ д/с / ШЗП-220/	ш	2	4			
3е	Кабелийн газардуулга	ш	2	2	2	4	
4	Резинэн бээлий	Хос	2	2	2	Бригад бүрт	10
5	Резинэн дэвсгэр	М2	8	8	6		6
6	Бот	Хос	2	2	2	2	5
7	Толгой хамгаалах хэрэгсэл	ш	2	2	2	Хүн бүрт	Хүн бүрт
8	Нүд хамгаалах хэрэгсэл	ш	2	2	2	Хүн бүрт	Хүн бүрт
9	Дөрөө бүс	ш				Хүн бүрт	Хүн бүрт
10	Хөндийрүүлэгдсэн бариултай монтерийн багаж МИ-64	Кон	2	2	2	4	Хүн бүрт
11	Галош	Хос	2	2	2	4	Хүн бүрт
12	Хамгаалалттай гүвц	Ш	2	2	2	Бригад бүрд	Брига д бүрд
13	Гар чийдэн	Ш	2	2	2	Бригад бүрд	Брига д бүрд
14	Зөөврийн гэрэлтүүлэг	ш	1	1	1	1	2
15	Гагнуурын баг	Ш	1	1	1	1	1

В хавсралт
(мэдээллийн)

Хүснэгт В.1

Ашиглалтанд байгаа хувийн хамгаалах хэрэгслийн дэлгэрэнгүй бүртгэл

№	Хам гаалах хэрэгсли йн нэр	Марк	Үйлдвэрлэгдсэн он сар өдөр	Ашиглалтад орсон он сар	Ээлжит туршилтад орсон он сар өдөр				Ашиглалтаас хасагдсан

Тайлбар: Хувийн хамгаалах хэрэгслийн нэг бүрчлэн бүртгэсэн байна.

Хүснэгт В.2

Ашиглалтад байгаа ажлын багажийн дэлгэрэнгүй бүртгэл

№	Ажлын багажны нэр	Марк	Тоо ширхэг	Үйлдвэрлэсэн үйлдвэр	Үйлдвэрлэсэн он сар	Ашиглалтад орсон он сар өдөр	дугаар	Ашиглалтаас хасагдсан шалтгаан
1								

С хавсралт
(мэдээллийн)

Хүснэгт С.1

Хувийн хамгаалах хэрэгслийн захиалга хийх маягт

№	Хамгаалах хэрэгслийн нэр	Марк	Үйлдвэрлэсэн үйлдвэр	Шаардлагатай тоо хэмжээ оноор		

Хүснэгт С.2

Ажлын тусгай хувцасны захиалга хийх маягт

№	Овог нэр	Алба салбар, хэсэг бригад	Албан тушаал	Зуны хувцас		Өвлийн хувцас	
				хэмжээ	өндөр	хэмжээ	өндөр